



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/006/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Орхонтуул сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Пийк Ом Аудит” ХХК Захирал: Б.Жаргалсайхан Утас: 99862066 Цахим хаяг: peakomauditllc@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ОРХОНТУУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Т.САРАНЧИМЭГ ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/006/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургууль нь аймгийн Боловсролын газраас 688.4 мянган төгрөгийн ном сурах бичиг, 14,020.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 41,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж зэрэг нийт 56,208.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй авч орлогод бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 12 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. БАТМӨНХ

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	131,017,537.23	92,869,633.10
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		131,017,536.23	92,869,633.10
31211	Төрийн сангийн харилцах		131,017,537.23	92,869,633.10
33	АВЛАГА	5	1,266,702.64	1,266,702.64
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,266,702.64	1,266,702.64
333	Байгууллагаас авах авлага			
35	БАРАА МАТЕРИАЛ	6	115,322,393.70	89,655,361.15
351	Түүхий эд материал		38,169,000.00	38,169,000.00
3511	Тусгай зориулалттай материал		38,169,000.00	38,169,000.00
354	Хангамжийн материал		77,153,393.70	51,486,361.15
3541	Бичиг хэргийн материал		3,154,200.00	0.00
3542	Аж ахуйн материал		38,630,984.03	17,620,905.88
3543	Сэлбэг хэрэгсэл		1,620,000.00	1,540,000.00
3546	Хүнсний материал		3,784,500.00	1,646,650.00
3547	Бусад хангамжийн материал		29,963,709.67	30,678,805.27
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		247,606,633.57	183,791,696.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,183,479,492.86	1,150,437,547.50
392	Биет хөрөнгө		1,144,125,492.86	1,111,083,547.50
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,173,761,800.00	1,173,761,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл		-273,473,690.62	-320,424,162.58
39203	Авто-тээврийн хэрэгсэл		14,912,500.00	0.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-14,912,500.00	0.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		313,286,974.25	237,362,402.15
39206	Хуримтлагдсан элэгдэл		-137,144,786.81	-85,878,171.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		119,331,203.20	133,388,943.20
39208	Хуримтлагдсан элэгдэл		-72,416,639.20	-44,861,924.55
39214	Бусад үндсэн хөрөнгө		27,236,632.00	18,328,569.50
39215	Хуримтлагдсан элэгдэл		-18,386,506.91	-11,697,833.19
39217	Ном		11,930,506.95	11,103,924.72
393	Биет бус хөрөнгө		39,354,000.00	39,354,000.00
39301	Программ хангамж		1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-1,500,000.00	-1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		39,354,000.00	39,354,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,183,479,492.86	1,150,437,547.50
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,431,086,126.43	1,334,229,244.39
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	19,084,500.00	0.00
413	Өглөг		19,084,500.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг		19,084,500.00	0.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		19,084,500.00	0.00
51	Засгийн газрын хувь оролцоо		1,412,001,626.43	1,334,229,244.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		596,019,208.20	596,019,208.20
512	Хуримтлагдсан үр дүн		-389,104,988.24	-466,877,370.28
5121	Өмнөх үеийн үр дүн		-389,104,988.24	-389,104,988.24
5122	Тайлант үеийн үр дүн			-77,772,382.04
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,205,087,406.47	1,205,087,406.47
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,412,001,626.43	1,334,229,244.39
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,431,086,126.43	1,334,229,244.39

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,464,344,262.97	1,609,725,681.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,281,157,900.00	1,426,694,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,281,157,900.00	1,426,694,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	183,186,362.97	183,031,281.02
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,186,362.97	183,031,281.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	258,913,348.40	82,450,112.02
120	Нийтлэг татварын бус орлого	258,913,348.40	82,450,112.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,000,000.00	2,700,686.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	2,700,686.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	226,715,842.70	75,153,491.02
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	12,197,505.70	4,595,935.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,723,257,611.37	1,692,175,793.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,508,602,959.66	1,768,433,223.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,470,234,375.66	1,732,124,908.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	977,791,277.96	1,180,029,703.27
210101	Үндсэн цалин	605,339,256.58	685,062,482.98
210102	Нэмэгдэл	343,748,106.00	420,350,288.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	31,809,744.00
210104	Урамшуулал	28,703,914.38	42,807,188.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,815,282.69	145,662,365.75
210201	Тэтгэврийн даатгал	82,103,614.28	100,235,660.69
210202	Тэтгэмжийн даатгал	9,622,500.52	11,582,219.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,781,127.51	5,702,160.56
210204	Ажилгүйдлийн даатгал	4,545,409.37	5,628,425.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,762,631.01	22,513,899.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,531,762.97	181,854,281.02
210301	Гэрэл, цахилгаан	12,027,745.54	18,582,162.08
210302	Түлш, халаалт	162,022,297.43	161,652,398.94
210303	Цэвэр, бохир ус	1,481,720.00	1,619,720.00
2105	Нормативт зардал	36,550,970.00	33,716,340.00
210502	Хоол, хүнс	36,550,970.00	33,716,340.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,654,600.00	1,177,000.00
210604	Урсгал засвар	7,654,600.00	1,177,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,684,535.95	11,904,323.11

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,684,535.95	11,904,323.11
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	142,205,946.09	177,780,894.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,324,873.30	62,828,810.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,447,400.00	6,667,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,433,672.79	108,284,484.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,368,584.00	36,308,315.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,368,584.00	36,308,315.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,345,384.00	36,308,315.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,023,200.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,508,602,958.66	1,768,433,222.53
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	214,654,651.71	-76,257,429.89
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	1,514,952.15
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	1,514,952.15
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-1,514,952.15
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	214,654,651.71	-77,772,382.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,484,344,262.97	1,612,426,367.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,000,000.00	2,700,686.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,000,000.00	2,700,686.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,000,000.00	2,700,686.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	2,700,686.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,464,344,262.97	1,609,725,681.02
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,281,157,900.00	1,426,694,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,281,157,900.00	1,426,694,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	183,186,362.97	183,031,281.02
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,186,362.97	183,031,281.02
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,433,238,887.87	1,648,970,270.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,433,238,888.87	1,648,970,271.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,394,733,304.87	1,613,986,956.15

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	976,480,807.96	1,180,029,704.27
210101	Үндсэн цалин	601,806,571.58	685,062,483.98
210102	Нэмэгдэл	345,970,322.00	420,493,976.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт		31,809,744.00
210104	Урамшуулал	28,703,914.38	42,663,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,815,282.69	145,662,365.75
210201	Тэтгэврийн даатгал	82,103,614.28	100,235,660.69
210202	Тэтгэмжийн даатгал	9,622,500.52	11,582,219.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,781,127.51	5,702,160.56
210204	Ажилгүйдлийн даатгал	4,545,409.37	5,628,425.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,762,631.01	22,513,899.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175,531,762.97	181,854,281.02
210301	Гэрэл, цахилгаан	12,027,745.54	18,582,162.08
210302	Түлш, халаалт	162,022,297.43	161,652,398.94
210303	Цэвэр, бохир ус	1,481,720.00	1,619,720.00
2105	Нормативт зардал	41,855,042.00	32,903,490.00
210502	Хоол, хүнс	41,855,042.00	32,903,490.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,654,600.00	1,177,000.00
210604	Урсгал засвар	7,654,600.00	1,177,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,578,201.95	11,904,323.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,578,201.95	11,904,323.11
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,817,607.30	60,455,792.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,370,207.30	53,998,992.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,447,400.00	6,456,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,505,584.00	34,983,315.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,505,584.00	34,983,315.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,482,384.00	34,983,315.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,023,200.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	51,105,374.10	-36,543,904.13
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,675,000.00	1,604,000.00
	Дотоод эх үүсвэрээр	4,675,000.00	1,604,000.00
222001	Тоног төхөөрөмж	4,675,000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	0.00	1,604,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,675,000.00	-1,604,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	46,430,374.10	-38,147,904.13
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84,587,163.13	131,017,537.23
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,017,537.23	92,869,633.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	596,019,208.20	1,205,087,406.47	-389,104,988.24	1,412,001,626.43
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			-77,772,382.04	-77,772,382.04
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	596,019,208.20	1,205,087,406.47	-466,877,370.28	1,334,229,244.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,752,316,381.04	1,609,725,681.02	0.00	100.0
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,569,285,100.02	1,426,694,400.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,569,285,100.02	1,426,694,400.00	0.00	100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	183,031,281.02	183,031,281.02	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	183,031,281.02	183,031,281.02	0.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,700,800.00	2,700,686.00	114.00	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,700,800.00	2,700,686.00	114.00	100.0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,755,017,181.04	1,612,426,367.02	142,590,814.02	91.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,755,017,181.02	1,648,970,271.15	106,046,909.87	94.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,716,994,781.02	1,613,986,956.15	103,007,824.87	94.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,249,552,500.00	1,180,029,704.27	69,522,795.73	94.4
210101	Үндсэн цалин	760,621,000.00	685,062,483.98	75,558,516.02	90.1
210102	Нэмэгдэл	453,214,800.00	420,493,976.29	32,720,823.71	92.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	31,809,744.00	-31,809,744.00	
210104	Урамшуулал	35,716,700.00	42,663,500.00	-6,946,800.00	119.5

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,194,000.00	145,662,365.75	10,531,634.25	93.3
210201	Тэтгэврийн даатгал	106,212,000.00	100,235,660.69	5,976,339.31	94.4
210202	Тэтгэмжийн даатгал	12,495,600.00	11,582,219.63	913,380.37	92.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,247,700.00	5,702,160.56	545,539.44	91.3
210204	Ажилгүйдлийн даатгал	6,247,700.00	5,628,425.00	619,275.00	90.1
210205	Эрүүл мэндийн даатгал	24,991,000.00	22,513,899.87	2,477,100.13	90.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	181,854,281.02	181,854,281.02	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	18,582,162.08	18,582,162.08	0.00	100.0
210302	Түлш, халаалт	161,652,398.94	161,652,398.94	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,619,720.00	1,619,720.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	46,828,600.00	32,903,490.00	13,925,110.00	70.3
210502	Хоол, хүнс	46,828,600.00	32,903,490.00	13,925,110.00	70.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,177,000.00	1,177,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,177,000.00	1,177,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,473,100.00	11,904,323.11	4,568,776.89	72.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			0.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,473,100.00	11,904,323.11	4,568,776.89	72.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,915,300.00	60,455,792.00	4,459,508.00	93.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,458,500.00	53,998,992.00	4,459,508.00	92.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,456,800.00	6,456,800.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,022,400.00	34,983,315.00	3,039,085.00	92.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,022,400.00	34,983,315.00	3,039,085.00	92.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,022,400.00	34,983,315.00	3,039,085.00	92.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			0.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		3,208,000.00	-3,208,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		3,208,000.00	-3,208,000.00	
222001	Тоног төхөөрөмж		0.00	0.00	
223001	Бусад хөрөнгө		3,208,000.00	-3,208,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,755,017,180.02	1,652,178,271.15	102,838,908.87	94.1
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84,587,163.13	131,017,537.23	-131,017,537.23	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,017,537.23	92,869,633.10	-92,869,633.10	
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	41	1	97.6
6	Удирдах ажилтан	3	3		100.0
7	Гүйцэтгэх ажилтан	24	23	1	95.8
8	Үйлчлэх ажилтан	15	15		100.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **56,092.1** мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс **4,879.0** мянган төгрөгийн 1 зөрчилд **албан шаардлага**, **51,213.1** мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **4,879.0** мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,207.0 мянган төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

5.1.2 Батлагдаагүй орон тоонд архив, бичиг хэргийн ажлын номын санчаар, цахилгаанчны ажлыг жижүүрээр хавсран гүйцэтгүүлэхээр томилж 4,879.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоог мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн тооллоготой холбоотой

1.1 Илрүүлэлт: Бараа материалын дансанд бүртгэлтэй 49,946.4 мянган төгрөгийн хангамжийн болон аж ахуйн материалын тооллогыг үнэн зөв бодитой явуулаагүй, хөрөнгийг тоолсон тоо хэмжээ байхгүй, чанар байдлыг тодорхойлж тооллогын илтгэх хуудас бичээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-т “Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.3 Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалын тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж байх зөвлөмж хүргүүлээ.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Авлагатай холбоотой

2.1 Илрүүлэлт: Он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй 1,266.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх авлагыг барагдуулах ажил зохион байгуулж, холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 - ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдаагүй орон тоог хавсран гүйцэтгэсэн гэх үндэслэлээр цалин олгосон.	1	4,879.0			1	4,879.0						
Бараа материалын тооллогыг үнэн зөв бодитой явуулаагүй.	1	49,946.4					1	49,946.4				
Он дамжсан авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	1,266.7					1	1,266.7				
Дүн	3	56,092.1			1	4,879.0	2	51,213.1				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			